



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хандизель ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/038/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2026 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 326

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хандизель ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй "Нутгийн дэм" хөтөлбөрт хамрагдаж, байгууллагын албан хаагчдад нийт 233,407.2 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Аудитын гол асуудал

Ханбогд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 508,797.5 мянган төгрөгийн ухаалаг худгийн ажил хийгдэж, тээврийн хэрэгсэл нийлүүлэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус үйлдвэрийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгагдсан асуудал нь хамаарахгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

4626050479

Г.Ц.Бичиг харах 2025 оны СТОУС-ын дүгнэлт Төсвийн Дэх

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
2	Эргэлтийн хөрөнгө	-	-
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	516,321,739.80	8,732,959.11
4	Дансны авлага	257,959,832.24	415,602,410.63
5	Татвар, НДШ-ийн авлага	-	-
6	Бусад авлага	-	-
8	Бараа материал	389,514,374.86	130,699,259.46
9	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,163,795,946.90	555,034,629.20
14	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
15	Үндсэн хөрөнгө	11,908,864,549.25	11,161,015,781.05
23	Биет бус хөрөнгө	2,354,734,545.61	2,357,620,454.67
24	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,263,599,094.86	13,518,636,235.72
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,427,395,041.76	14,073,670,864.92
26	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
27	Өр төлбөр	-	-
28	Богино хугацаат өр төлбөр	-	-
31	Татварын өр	64,522,207.50	27,555,645.32
32	НДШ-ийн өглөг	-	-
36	Урьдчилж орсон орлого	-	-
38	Бусад богино хугацаат өр төлбөр	10,299,400.00	894,909.00
41	Богино хугацаат өр төлбөрийн дүн	74,821,607.50	28,450,554.32
42	Урт хугацаат өр төлбөр	-	-
43	Урт хугацаат зээл	-	-
46	Бусад урт хугацаат өглөг	11,239,324,785.36	10,458,561,998.53
48	Урт хугацаат өр төлбөрийн дүн	11,239,324,785.36	10,458,561,998.53
49	Өр төлбөрийн нийт дүн	11,314,146,392.86	10,487,012,552.85
50	Эздийн өмч	-	-
51	Өмч: а) төрийн	749,177,855.36	749,177,855.36
56	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	49,945,918.75	49,945,918.75
58	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	2,350,530,000.00	2,350,530,000.00
59	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	963,594,874.79	437,004,537.96
61	Эздийн өмчийн дүн	4,113,248,648.90	3,586,658,312.07
62	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,427,395,041.76	14,073,670,864.92

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,521,692,477.85	2,730,280,207.81
2	Борлуулалтын өртөг	3,355,021,119.01	4,593,099,538.27
3	Нийт ашиг	(815,339,747.62)	(1,862,456,330.46)
5	Хүүний орлого	4,625,733.04	2,439,611.90
7	Эрхийн шимтгэлийн орлого	1,060,001,749.66	-
8	Бусад орлого	326,323,495.00	1,524,448,812.83
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	234,610,975.99	190,659,431.10
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	700,000.08	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг алдагдал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	322,311,360.47	(526,590,336.83)
19	Орлогын татварын зардал	32,231,136.04	-
20	Татвар дараах ашиг (алдагдал)	290,080,224.43	(526,590,336.83)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	290,080,224.43	(526,590,336.83)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
27	Орлогын нийт дүн	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	3,099,707,855.36	49,945,918.75	963,594,874.79	4,113,248,648.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	3,099,707,855.36	49,945,918.75	963,594,874.79	4,113,248,648.90
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	(526,590,336.83)	(526,590,336.83)
2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	3,099,707,855.36	49,945,918.75	437,004,537.96	3,586,658,312.07

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2	Мөнгөн орлогын дүн (+)	2,950,980,419.93	3,067,693,912.18
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	156,757,787.57	2,794,440,216.28
8	Бусад мөнгөн орлого	2,794,222,632.36	273,253,695.90
9	Мөнгөн зарлагын дүн (-)	2,784,195,122.02	3,499,550,336.26
10	Ажиллагчдад төлсөн	873,588,580.00	1,477,189,039.00
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	249,005,831.34	427,031,972.39
12	Бараа материалын худалдан авахад төлсөн	991,262,545.10	586,967,215.44
13	Ашиглалтын зардалд төлсөн	180,204,536.27	294,602,236.93
14	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	197,876,459.00	312,864,270.00
15	Хүүний төлбөрт төлсөн	462,719.71	117,606.41
16	Татварын байгууллагад төлсөн	290,610,250.60	396,165,648.81
18	Бусад мөнгөн зарлага	1,184,200.00	4,612,347.28
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	166,785,297.91	(431,856,424.08)
20	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
21	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
22	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
23	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
24	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
30	Мөнгөн зарлагын дүн (-)	-	75,732,356.61
31	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	75,732,356.61
32	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
33	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
37	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(75,732,356.61)
38	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
39	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
40	Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
44	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
45	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
46	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
47	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
50	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
51	Валютын ханшийн зөрүү	-	-
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	166,785,297.91	(507,588,780.69)
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	349,536,441.89	516,321,739.80
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	516,321,739.80	8,732,959.11

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Тайлант оны (2025)			
		2025 Батлагдсан төлөвлөгөө	2025 Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Нийт борлуулалтын орлого	3,965,201,459.00	4,257,168,632.54	291,967,173.54	107.4
	Үйл ажиллагааны борлуулалтын орлого	3,965,201,459.00	4,257,168,632.54	291,967,173.54	107.4
1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих/ Дулаан борлуулсны орлого	1,516,818,100.00	1,572,072,130.90	55,254,030.90	103.6
2	Ус хамгамаж, ариутгах татуурга/	650,456,550.00	926,355,358.32	275,898,808.32	142.4
5	Бусад орлого үйл ажиллагааны	289,800,000.00	108,061,284.43	(181,738,715.57)	37.3
1	Банкны хүүний орлого	12,000,000.00	2,439,611.90	(9,560,388.10)	20.3
	техникийн нөхцөл олгосон орлого	15,000,000.00	1,260,000.00	(13,740,000.00)	8.4
	холболтын орлого	70,125,000.00	108,956,931.80	38,831,931.80	155.4
	карт тоолуур орлого	12,500,000.00	15,055,823.36	2,555,823.36	120.4
2	Бусад орлого (Нутгийн дэм)	354,120,000.00	233,407,230.00	(120,712,770.00)	65.9
3	Бусад орлого (Хойшлогдсон хөрөнгийн орлого)	1,044,381,809.00	1,289,560,261.83	245,178,452.83	123.5
1	НИЙТ ЗАРЛАГА	3,960,141,099.00	4,783,758,969.37	823,617,870.37	120.8
2	Ажилчдын цалин	1,427,652,000.00	1,765,689,563.00	338,037,563.00	123.7
3	НДШ,ЭМД	207,009,540.00	234,965,944.39	27,956,404.39	113.5
4	Элэгдлийн зардал	642,165,835.00	102,432,428.92	(539,733,406.08)	16.0
5	Хойшлогдсон хөрөнгийн элэгдэл	-	1,289,560,261.83	1,289,560,261.83	-
6	Албан томилот	12,000,000.00	14,079,090.91	2,079,090.91	117.3
7	Шуудан холбоо	10,644,348.00	6,433,285.90	(4,211,062.10)	60.4
8	Банкны шимтгэл	351,000.00	550,402.28	199,402.28	156.8
9	Мэргэжлийн ажил, үйлчилгээний хөлс	120,000,000.00	61,134,163.63	(58,865,836.37)	50.9
10	Сургалтын зардал	34,972,728.00	34,900,661.45	(72,066.55)	99.8
11	Цахилгаан	225,000,000.00	267,821,214.90	42,821,214.90	119.0
12	Шатахуун	180,000,000.00	156,199,779.38	(23,800,220.62)	86.8
13	Тээврийн зардал	289,800,000.00	31,426,454.55	(258,373,545.45)	10.8
14	Хөдөлмөр хамгаалал	155,000,000.00	160,793,994.72	5,793,994.72	103.7
15	Бичиг хэрэг	12,000,000.00	20,136,327.40	8,136,327.40	167.8
16	Сэлбэг	146,254,992.00	106,593,163.43	(39,661,828.57)	72.9
17	Хангамжийн материал	170,000,000.00	253,434,149.87	83,434,149.87	149.1
18	Албан татвар төлбөр хураамж	20,490,656.00	14,721,953.49	(5,768,702.51)	71.8
19	Бусад зардал	306,800,000.00	262,886,129.32	(43,913,870.68)	85.7
	Нийт зардлын дүн	3,960,141,099.00	4,783,758,969.37	823,617,870.37	120.8
	Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	5,060,360.00	(526,590,336.83)	(531,650,696.83)	(10,406.2)
	Орлогын татварын зардал	506,036.00	-	(506,036.00)	-
	Татвар дараах ашиг/алддагдал	4,554,324.00	-	(4,554,324.00)	-
	Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал	4,554,324.00	(526,590,336.83)	(531,144,660.83)	(11,562.4)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдааг илрээгүй болно.

Аудитаар 37.8 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 22.0 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 15.8 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 16.1 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

1. Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй 4 ажилтанд 6.0 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно.", Захирлын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод" журмын 8.7-д "Сахилгын шийтгэл ногдуулсан хугацаанд буюу сахилгын шийтгэлгүйд тооцогдох хүртэл ажилтныг аливаа шагнал урамшуулалд хамруулахгүй" гэж заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн дотоод журмын заалтын дагуу урамшуулал олгохдоо сахилгын шийтгэл авсан байдлыг харгалзан үзэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацааны эцсээр татварын байгууллагад үүссэн 6.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Тус байгууллага нь 9.7 сая төгрөгийн зөөврийн компьютер, принтерийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 29 нэр төрлийн үндсэн хөрөнгүүдийн үнэлгээг хийж, ашиглах хугацаа, өртгийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйл 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" заалт, Сангийн сайдын 2014 оны 249 тоот тушаалд "Хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхыг тухайн

байгууллага хүртэх магадлалтай ба хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ нөхсөн боловч үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор тодорхойлж, холбогдох бүртгэлийг НББОУС 16 Үндсэн хөрөнгөд заасны дагуу хэрэгжүүлэх;

Илрүүлэлт 2: Жилийн эцсийн хөрөнгийн тооллого зохион байгуулах захирлын тушаал гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах"; 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана." гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жилийн эцсийн тооллого хийх ажлыг зохион байгуулах тухай шийдвэрийг хуулийн хугацаанд нь гарган хэрэгжүүлж ажиллах;

2. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь гэрээ, шийдвэргүй 15.8 сая төгрөгийн сургалтын төлбөрийн ажил гүйлгээ гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 19 дүгээр зүйлийн 19.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тус байгууллага нь гэрээ, шийдвэргүй 15,810.8 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн ажил гүйлгээ гаргасан.	1	15,810.8	-	-	-	-	1	15,810.8	-	-	-	-
2	Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй 4 ажилтанд 5,983.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон	1	5,983.2	-	-	1	5,983.2	-	-	-	-	-	-
3	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 29 нэр төрлийн үндсэн хөрөнгүүдийн үнэ болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоолгоогүй бүртгэсэн.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
4	Тайлант хугацааны эцсээр татварын байгууллагад үүссэн 6,317.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	6,317.6	-	-	1	6,317.6	-	-	-	-	-	-
5	Жилийн эцсийн хөрөнгийн тооллого зохион байгуулах захирлын тушаал гаргаагүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
6	Тус байгууллага нь 9,712.6 мянган төгрөгийн зөөврийн компьютер, принтерийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй.	1	9,712.6	-	-	1	9,712.6	-	-	-	-	-	-
	Дүн	6	37,824.2	-	-	3	22,013.4	3	15,810.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Өмнөговь аймгийн засагт даргаар батлуулсан бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаагүй 526,590.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	1	526,590.6	-	-	-	-	-	-	1	526,590.6
	Дүн	1	526,590.6	-	-	-	-	-	-	1	526,590.6